

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗДТГ-ЫН АВЛИГЫН ЭСРЭГ
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**


БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан
1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт					
1	Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэр, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас гаргах шийдвэрийн төслийн талаар төрийн болон ТББайгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах.	1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэр, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас гаргах шийдвэрийн төслүүдийн талаар иргэд, олон нийтээс санал хүлээж авах, тусгах, эргэж мэдээлдэг механизм бүрдүүлэх /цахим хуудас, санал асуулга, саналын хайрцаг, утсаар авч эргэж мэдээлдэг болох/	2 удаа	Хууль эрх зүйн мэргэжилтэн Г. Доржханд	Багийн Засаг дарга нар
		1.2. Орон нутгийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах	3-6 сард	Санхүүгийн албаны дарга О.Отгонтуяа	Байгууллага хариуцсан нягтлан бодогч нар
		1.3. Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал /нууцад хамааруулснаас бусад/-ыг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод болгох	1-12 сард	Хууль эрх зүйн мэргэжилтэн Г. Доржханд	Засаг дарга ЗДТГ-ын дарга
2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг хууль журамд заасны дагуу шийдвэрлэх.	2.1. Авлигын эсрэг 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг тухай бүр нь тооцож шийдвэрлэсэн байх.	Тухай бүр	Н. Бат-Эрдэнэ Ч. Батдулам	Санхүүгийн албаны дарга
3	Байгууллагын хяналт шалгалтыг үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг	4.1. Аудитын газраас явуулсан хяналт, шалгалтын мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх, байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулах.	Тухай бүр	Санхүүгийн албаны дарга О.Отгонтуяа	Байгууллага хариуцсан нягтлан бодогч нар

	хангах, үр дүнг нээлттэй мэдээлэх.	4.2. Байгууллагын дотоод хяналтын багийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, ажлын тайлан болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд илтгэх.	Тухай бүр	Хууль эрх зүйн мэргэжилтэн Г. Доржханд	ЗДТГ-ын дарга
4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	4.1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах мөн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим болон мэдээллийн самбарт байршуулах	5 сарын 1-ний дотор	О. Отгонтуяа Э.Дашдулам	Байгууллага хариуцсан нягтлан бодогч нар
		4.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	1-12 сар	Татварын улсын байцаагч Н.Батсайхан	БОХ-ын улсын байцаагч Байгаль хамгаалагч нар
		4.3. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх, цахим хуудсанд байршуулж хэвших	1-12 сард	МЭҮТасгийн мэргэжилтэн Н. Түвшин	
		4.4. Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж сурталчлах	1-12 сард	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Г.Цэрэндулам	Санхүү албан дарга
		4.5. ЖДҮД сан, сум хөгжүүлэх сан зэрэг улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа зээл, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зарцуулалтад ТББ, иргэдийн оролцоотой мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж гарган хариуцлага тооцож ажиллах	6-11 дүгээр сард	ХААТасгийн мэргэжилтэн Н. Түвшин	Сумын ИТХ-ын хяналтын зөвлөл
5	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	5.1. Төрийн албаны сул орон тооны зарыг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах, сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах	Тухай бүр	Н. Бат-Эрдэнэ Г. Доржханд	Хууль эрх зүй мэргэжилтэн
		5.2. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх.	1-12 дугаар сард	Н. Бат-Эрдэнэ	Албан байгууллагуудын дарга, эрхлэгч нар
		5.3.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах.	1-12 дугаар сард	Н. Бат-Эрдэнэ	Хууль эрх зүй мэргэжилтэн

6	Ашиг зөрчлөөс сэргийлэх дүрмийг мөрдүүлэх.	сонирхлын урьдчилан ёс зүйн тогтоон	6.1. Байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн тайлан, мэдээг тайлагнах.	1-12 дугаар сард	Б. Янжиндулам	ЗДТГ-ын дарга
7	Иргэдийн /санал, гомдол, хүлээн шийдвэрлэх шат дамжлагыг зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	өргөдөл мэдэгдэл/хүсэлтийг авах, шат цөөрүүлэх, дамжлагыг талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	7.1. Өргөдөл /санал мэдэгдэл/гомдол, хүсэлт, мэдээллийг шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр,цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр/	1-12 дугаар сард	Г. Сарантуяа	Хууль эрх зүй мэргэжилтэн
			7.2. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, шуурхай шийдвэрлэн, хариуг тогтмол хугацаанд мэдээлэх	1-12 дугаар сард	Г. Сарантуяа	ЗДТГ-ын дарга
8			8.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хувийн хэрэг нээж, баяжуулалт хийж, холбогдох газарт цаг тухай бүр хугацаанд нь тайлагнах.	жилдээ	Н.Бат-Эрдэнэ	Хууль эрх зүй мэргэжилтэн

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ЗДТГ-ЫН ДАРГА





Н.БАТ-ЭРДЭНЭ




**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗДТГ-ЫН АВЛИГЫН ЭСРЭГ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



2021.11.15

Өвт



Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт		
1	Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэр, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас гаргах шийдвэрийн төслийн талаар төрийн болон ТББайгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах.	
	Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэр, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас гаргах шийдвэрийн төслүүдийн талаар иргэд, олон нийтээс санал хүлээж авах, тусгах, эргэж мэдээлдэг механизм бүрдүүлэх /цахим хуудас, санал асуулга, саналын хайрцаг, утсаар авч эргэж мэдээлдэг болох/	Сумын ИТХурал, Засаг даргаас гарах шийдвэрийн төсөл болох “Хог хаягдал тээвэрлэж цуглуулах журам”, “Архи, согтууруулах ундаа худалдах, тусгай зөвшөөрөл олгох, Худалдаа эрхлэгчид зориулалтын бус газар худалдаа эрхлэх асуудлыг зохицуулах, мөн ойн унанги хаягдлыг ашиглах талаар нийт 700 –аад иргэний санал хүсэлтийг авч, шийдвэрүүдэд тусган баталгаажуулсан. Шийдвэрүүдийг мэдээллийн самбар, сумын цахим хуудсаар мэдээлсэн.
1.3	Орон нутгийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах	Орон нутгийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж иргэдээс санал асуулга авч хэлэлцэж батлуулдаг. Батлагдсан төсвийг хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулж, байгууллагын цахим хуудас болон ил тод байдлын мэдээллийн самбарт тавьж хэвшсэн. 
1.4	Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал /нууцад хамааруулснаас бусад/ -ыг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод болгох	Сумын Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой 183 ,боловсон хүчний 27 захирамж, ЗДТГ-ын даргын үйл ажиллагаатай холбоотой 24 тушаал, боловсон хүчний 15 тушаал гарсныг /нууцад хамаарснаас бусад/ цахим болон мэдээллийн самбарт байршуулан ил тод мэдээлж байна.
Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх		
2.1	Авлигын эсрэг 2021 оны үйл ажиллагааны	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 300,0 мян


	төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг тухай бүр нь тооцож шийдвэрлэсэн байх.	төгрөгийг тараах материал, сургалт сурталчилгааны зардалд зарцуулсан.
Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах		
3.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах./мэдээллийн самбар, цахим хуудас, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	Авлигын эсрэг хууль, холбогдох заавар журмын талаар хэсэгчилсэн БИНХурлуудаар товч мэдээлж, гарын авлага 250 ш-ийг бэлтгэн албан байгууллагуудын мэдээллийн самбар, нэг цонхны үйлчилгээний төвд, иргэдэд сурталчлан ажилласан.
Байгууллагын хяналт шалгалтыг үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, үр дүнг нээлттэй мэдээлэх.		
4.1	Аудитын газраас явуулсан хяналт, шалгалтын мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх, байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулах.	Аудитын газраас явуулсан хяналт шалгалтын мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тавьж хэвшсэн. 
4.2	Байгууллагын дотоод хяналтын багийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, ажлын тайлан болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд илтгэх.	Байгууллагын дотоод хяналтын баг нь тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд 10-р сард хэлэлцүүлэхээр тусгасан. ЗДТГ-ын хурлаар дотоод хяналтын багийг 2021 оны 10-р сарын 20 нд шинэчилэн байгуулсан.
Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх		
5.1	Тухайн жилийн төсөв /1-р сарын 20-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 –р сарын 10-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8-р сарын 25-ны дотор/ -ийг	2021 оны батлагдсан төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулж мэдээлсэн.

	цахим хуудсанд байршуулах.	 
5.2	Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах мөн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим болон мэдээллийн самбарт байршуулах	2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулж санхүүгийн ил тод байдлын самбарт тавьсан. Мөн жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд байршуулж, байгууллагын ил тод байдлын самбарт тавьсан.
5.3	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах.	сумын ИТХ-аар ОНТөсөвт өөрчлөлт оруулах талаар 2021 оны 12-р сарын 19 ны хурлаар оруулахаар төлөвлөсөн. Өөрчлөлтийг тухайн үед нь шилэн дансанд байршуулж , мэдээллийн самбарт тавьсан. 
5.4	Төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	Сар бүр төрийн сантай татварын болон татварын бус орлогын мэдээг нийлэн хуулга боловсруулан Татварын хэлтсийн мэдээллийн тасагт хүргүүлэн, мэдээллийн самбарт тавьж иргэдэд нээлттэйгээр мэдээлж, сумын удирдлагуудад цаасаар хэвлэн хүргүүлэн ажилласан.

			
5.5	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх, цахим хуудсанд байршуулж хэвших	Солонгосын Ротари клубээс Бат-Өлзий сумын ЕБСургууль төгсөөд анагаахын чиглэлээр суралцаж байгаа 6 оюутанд сургалтын төлбөрийн 50%-ийн санхүүжилтийг өгсөн. Тус мэдээллийг Бат-Өлзий сумын нэгдсэн facebook хаягаар иргэдэд нээлттэйгээр мэдээлэл хүргэсэн.	
5.6	Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж сурталчилах	2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг info.shilendans.gov.mn , tender.gov.mn сайт болон ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулсан.	
5.7	Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт тавих иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх хүрээнд мэдээллийг байгууллагын цахим хаяг, мэдээллийн самбар, олон нийт хурал, сурталчилгааны өдөрлөг зохион байгуулж түгээх	ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрт тавих иргэд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлсэн. БИНХурлаар мэдээлэл хийж, хийгдэж буй ажил тус бүр дээр хяналтын баг ажиллуулж байна.	
5.8	ЖДҮД сан, сум хөгжүүлэх сан зэрэг улсын	Тогтвортой амьжиргаа-Чадваржсан иргэн төслийн хүрээнд Сум хөгжүүлэх сангийн үйл	

	төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа зээл, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зарцуулалтад ТББ, иргэдийн оролцоотой мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж гарган хариуцлага тооцож ажиллах	ажиллагаанд хөндлөнгийн аудит, шалгалт хийж шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж ирүүлсэний дагуу хугацаа хэтэрсэн 8 иргэнд Засаг даргын албан шаардлага хүргүүлж, тодорхой арга хэмжээг авч ажилласан.
Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах		
6.1	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны талаар улирал тутам мэдээлийн самбар болон БИНХурлуудаар мэдээлэх	Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2015.10.23 ны өдрийн №72 дугаар тогтоолын дагуу сумын ИТХТэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 01 ны өдрийн № 14 тоот тогтоолоор Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход санал дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус “ Ажлын хэсэг” байгуулж, 2016.03.02 ны өдрийн №16 тоот тогтоолоор “ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх,тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох хяналт тавих журмыг батлуулан,журмын 4.2 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн иргэдийн хүсэлтийг хүлээн авч 2021 онд ажлын хэсгээс гарсан дүгнэлтүүдийг үндэслэн 3 хүнсний дэлгүүрт тусгай зөвшөөрөл олгох, сунгалт хийгдэх материалыг бүрдүүлэн аймгийн ЗДТГазрын хууль эрх зүйн хэлтэстуламжилж архи согтууруулах ундааны тусгай зөвшөөрлын шаардлага хангасан газруудтай сумын Засаг Дарга хамтран ажиллах гэрээ байгуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг жагсаалтаар гарган ЗДТГазрын мэдээллийн самбарт улирал бүр байршуулан ажиллаж байна.
Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах		
7.1	Төрийн албаны сул орон тооны зарыг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах, сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах	ЗДТГазарт төрийн албаны сул 2 орон тооны зарыг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулан, төрийн албаны сонгон шалгаруулалтын ажлын байранд нээлттэй зарлагдсан.
7.2	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх.	Төрийн албан хаагчдын бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөнийг хүний нөөцийн удирдлагын программд жил бүр шинэчлэн аймгийн ТЗУХэлтэст хүлээлгэн өгч, ил тод мэдээлсэн. Сумын хэмжээнд нийт 225 төрийн албан хаагч мэдээллийн санд бүртгэгдсэн. ЕБСургуульд 3 багшийг сонгон шалгаруулж авсан.
7.3	Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах.	2021 оны эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд албан хаагч бүрийг өөрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаар болон холбогдох хууль тогтоомжийн дагуу сургалт, мэдээлэл хийхээр тусгаж, БИНХурлууд дээр хариуцсан ажлын чиг үүргийн талаарх мэдээллүүдийг иргэдэд нээлттэй байдлаар хүргэсэн. Албан хаагчдын ажлын байрны цаг ашиглалтын хуваарь /ажиллаж байгаа, гадуур ажилтай, чөлөөтэй, өвчтэй, томилолттой гэсэн заалтаар/, ажлын байранд гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийн талаарх мэдээллийг албан хаагч бүрийн хаалган дээр ил тод байршуулсан.

		
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах		
8.1	<p>Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг журмын хүрээнд үргэлжлүүлэх, ХАА-ы журам, холбогдох бусад мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод болгох, үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулах</p>	<p>Худалдан авах ажиллагааны хууль журмын дагуу явуулж байгаа бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг иргэдэд таниулж, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний саналыг иргэдээс авч нэн тэргүүнээр эрэмблүүлж батлуулдаг. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн өргөн чөлөөний зам засварын ажлыг цахим тендерээр зарлаад байна.ХАА-ны үйл ажиллагааны явцыг иргэдэд нээлттэй, ил тод байлгах аар мэдээллийг info.shilendans.gov.mn, tender.gov.mn сайт болон ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулдаг.</p> 
8.2	<p>Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нээлттэй мэдээлэх.</p>	<p>Бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тайланг хагас жилээр гарган ХБХэлтэст явуулсан бөгөөд ил тод байдлын мэдээллийн самбарт мэдээлж хэвшсэн.</p>

8.3	Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийг цахим хуудсаар мэдээлэх.	Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг Г info.shilendans.gov.mn сайтад байршуулан ажилладаг. Мөн tender.gov.mn сайтад мэдээллийг байршуулан ажилладаг.
8.4	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, бусад хяналт шалгалтын дүнг мэдээлэх ажлыг тогтмолжуулах.	<p>2021 оны ОНХСангийн худалдан авах ажиллагаанд аудитын шалгалт хийгдсэн бөгөөд аудитын тайланг тухайн үед нь шилэн дансанд байршуулж ил тод байдлын самбарт мэдээлж хэвшсэн.</p> 
Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх.		
9.1	Байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн тайлан, мэдээг тайлагнах.	Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх шийдвэрлэх журам”-ын 2.5.1 заалтыг дагуу /төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах/ ЗДТГ-ын албан хаагчид нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн дүрмийг сахин олон нийтэд тайлагнаж ажилдаг. ЗДТГ-ын хурлаар ёс зүйн зөвлөлийг 2021 оны 10-р сарын 20-нд шинэчилэн байгуулж үүрэг чиглэл өгч ажиллаж байна.
Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах		
10.1	Өргөдөл /санал мэдэгдэл/гомдол, хүсэлт, мэдээллийг шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр,цахим, бичгээр, амаар	Тус сумын ЗДТГазарт өргөдөл, гомдол, хүсэлтийг шуурхай хүлээн авах, утас, саналын хайрцаг, цахим хуудас байнга нээлттэй ажиллаж байна.

	г.м хэлбэрээр/	
10.2	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, шуурхай шийдвэрлэн, хариуг тогтмол хугацаанд мэдээлэх	2021 оны онд ЗДТГазар бичгээр 488 өргөдлийг бичиг хэргийн ажилтан хүлээн авч Засаг даргад танилцуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэн хуулийн хугацаанд нь 488 өргөдлийг шийдвэрлэн, хариуг эзэнд нь бичгээр, амаар, утсаар өгч ажилласан.
10.3	Газар эзэмшүүлэх, өмчлүүлэх асуудлаар гаргасан иргэдийн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх талаар чиглэл өгч ажиллах	Суманд 2021 онд эзэмшиж байсан газар өмчлөхийг хүсэх өргөдлийг тухай бүр шийдвэрлэсэн. Шинээр газар хүссэн өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, аялал жуулчлалын зориулалтаар 9 иргэний газарт хэмжилт хийсэн
11	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хувийн хэрэг нээж, баяжуулалт хийж холбогдох газарт цаг тухай бүр хугацаанд нь тайлагнах.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хувийн хэрэг нээж, баяжуулалтыг тухай бүр хийж цаг хугацаанд нь тайлагнасан.
2. Авлигатай тэмцэх санал, санаачилга		
Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт		
2.1	Байгууллагын менежментийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цагийн менежментийг эрс сайжруулах	Төрийн албан хаагчдын ажилдаа ирэх ажлын цагт байнгын хяналт тавьж, ажлын цагийг албан хаагч бүр долоо долоо хоногоор ээлжлэн бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.
Албан хаагчдын шударга байдал ба шударга ёсны үнэлэмжийг нэмэгдүүлэх		
2.1	Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчлийг шийдвэрлэн, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Албан хаагчдын ёс зүйн харилцаатай холбоотой санал гомдол 2021 онд иргэдээс ирээгүй
2.2	Байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчлийг шийдвэрлэн, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Албан хаагчдын ёс зүйн харилцаатай холбоотой санал гомдол 2021 онд иргэдээс ирээгүй.
2.3	Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.	Ёс зүйн зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөө гарган батлуулж, мөрдөн ажлаж байна. Түүний дагуу албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллана гэсэн гарын үсгийн баталгааг гаргуулан авч ажилласан.



2.4	Байгууллагын соёл, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтуудыг Тамгын газар болон бусад байгууллагуудад дотоодын нөөц бололцоогоор хийх.	Ёс зүйн зөвлөлийн нөөц бололцоонд тулгуурлан өөрсдийн санаачилгаар албан хаагчдын өрөөнүүдэд соёл, ёс зүй, харилцааны холбогдолтой зүйн үгийг хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан.
2.5	Байгууллага, албан тушаалтны ажлыг үнэлэхдээ иргэдийн оролцоог хангаж ажилласан байдлыг нэг үзүүлэлт болгон дүгнэж байх.	5 багийн ИНХурлаар албан хаагчдын ажилд сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх судалгааг ажлын нэг үзүүлэлт болгон дүгнэж байна.
2.6	Улс, аймгийн болон орон нутгийн чанартай уралдаан тэмцээнд аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэдээс өргөсөн хандив тусламжийг олон нийтэд ил тод мэдээлэх /хулдаасан хэвлэл, цахим сайт гэх мэт/	Улс, аймгийн уралдаан тэмцээн 2021 онд зохион байгуулагдаагүй. Орон нутагт зохион байгуулагдсан уралдаан тэмцээн зохион байгуулагдсан уралдаан тэмцээнийг ивээн тэтгэсэн иргэн, ААН-ийн хандив тусламжийг олон нийтэд ил тод сумын нэгдсэн сүлжээнд тухай бүр мэдээлэн ажилласан.

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН: ЗДТГ-ЫН ДАРГА



Н. БАТ-ЭРДЭНЭ